



Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2017 оны 12 сарын 28-ны өдрийн 3825 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 379

Улаанбаатар хот


Аргачлал батлах тухай

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь хэсэг, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах, татварын ногдлыг тодорхойлох аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан аргачлалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Татварын ерөнхий газар /Д.Занданбат/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Н.Нарангэрэл/-т тус тус даалгасугай.




Ч.ХҮРЭЛБААТАР

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Бүртгэлийн № 231

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Архивын эрхлэгч

Хийт 4х хуудас 20 он 12 сар 27 өдөр



ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХ БОРЛУУЛСНЫ ОРЛОГОДАЛБАН ТАТВАР НОГДУУЛАХ, ТАТВАРЫН НОГДЛЫГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аж ахуйн нэгж, хувь хүний газар эзэмших, ашиглах эрх (цаашид "газрын эрх" гэх) борлуулсны орлогод албан татвар ногдуулахад энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Газрын эрхтэй этгээд болон тэдгээрийн эцсийн эзэмшигч бусдад шилжүүлсэн хувьцаа, хувь оролцооноос тухайн газрын эрхтэй этгээдийн хувьцаанд ногдох хэмжээгээр газрын эрхийн үнэлгээнээс хувь тэнцүүлэн тооцож албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

Хоёр. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

2.1. Газрын эрх борлуулсны үнэлгээг тооцохдоо Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал"-ын дагуу тооцсон дуудлага худалдааны анхны үнээс багагүй байх зарчмыг баримтална.


2.2. Энэ аргачлалын 2.3, 2.4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд тухайн газрыг дуудлага худалдаагаар авахад шалгарсан үнэ болон татвар төлөгчөөс мэдүүлсэн газрын эрх худалдах, худалдан авах гэрээний үнийн аль өндөр үнээр газрын эрхийн борлуулалтын үнийг тооцно.

2.3. Газрын эрхийг өөр төрлийн хөрөнгө, үйл ажиллагаагаар харилцан солилцсон, эсхүл дуудлага худалдаагаар олгогдоогүй газрын эрх шилжүүлж байгаа тохиолдолд борлуулалтын үнэлгээг энэ аргачлалын 2.1-д заасан үнэ болон татвар төлөгчөөс ирүүлсэн газрын эрх шилжүүлэх гэрээний үнийн аль өндөр үнээр газрын эрхийн борлуулалтын үнийг тооцно.


2.4. Бусдаас үнэ төлбөргүй авсан газрын эрхийн орлогыг энэ аргачлалын 2.1-д заасан үнэлгээнд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу шууд бус аргаар тодорхойлох ба харилцан хамааралтай этгээдүүдийн хувьд бодит үнийн арга, харилцан хамааралгүй этгээдүүдийн хувьд жишиг үнийн аргад үндэслэнэ.

2.5. Газрын эрхтэй этгээд, түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар газрын эрхийн эцсийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд тухайн эрхийг шилжүүлснээс олсон орлогыг тодорхойлохдоо энэ аргачлалын 2.1-д заасны дагуу тооцсон үнэлгээнээс тухайн хувь эзэмшигчийн шилжүүлсэн хувьцаа, хувь оролцоонд ногдох хэмжээгээр хувь тэнцүүлэн тооцно.

2.6. Энэ аргачлалын 2.5-д заасан "эцсийн эзэмшигч" гэдгийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д зааснаар ойлгох ба эзэмшигчийн хувьцаанд ногдох хэмжээг хувь тэнцүүлэн тооцох аргачлалыг жишээгээр харуулбал:



Жишээ 1. Татвар ногдуулах тохиолдол



Албан татвар ногдуулах хувьцааны эрхэд ногдох үнэлгээ:
 $60\% \times 40\% = 24\%$ буюу үнэлгээний дүнгийн 24% хувьтай тэнцэх хэмжээний орлого олсон гэж үзнэ.


Жишээ 2: Татвар ногдуулахгүй тохиолдол




Дээрхи тохиолдолд эрх эзэмшигчийн 2-р шатанд 30 хувь эзэмшигч 2 компани нь зэрэг "эцсийн эзэмшигч" болох ба 20 хувь эзэмшигчийн хувьцаа зэмшигч хувьцаагаа борлуулсан тул татвар ногдохгүй.

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ
 ХУУЛБАР ҮНЭН
 Бүртгэлийн № 271
 Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
 2017 оны 12 сар 22 өдөр

Жишээ 3. Татвар ногдуулах тохиолдол



Жишээ 4: Татвар ногдуулахгүй тохиолдол



0000000000

